**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 10 сарын 06 өдөр Дугаар А/209. Улаанбаатар хот

Ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам,
шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын 3 дахь хэсэг "Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын журам", Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 5 дугаар зүйлийн 5.7, 5.8, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д заасныг тус тус ТУШААХ нь:

1. "Төвийн ерөнхий захирлын мэдлийн дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, оноо, урамшуулал олгох хувь хэмжээ"-г нэгдүгээр, "Тасгийн эрхлэгч, эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, оноо, урамшуулал олгох хувь хэмжээ"-г хоёрдугаар, "Албадын дарга нар, мэргэжилтний ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, оноо, урамшуулал олгох хувь хэмжээ"-г гуравдугаар, "Ахлах сувилагч, сувилагч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, оноо, урамшуулал олгох хувь хэмжээ"-г дөрөвдүгээр, "Эрүүл мэндийн бусад ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, оноо, урамшуулал олгох хувь хэмжээ"-г тавдугаар, үр дүнгийн үнэлгээний хяналтын хуудасны загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан журам, шалгуур үзүүлэлтийг харьяалан удирдах эмч, ажилтнуудад танилцуулж, өмнөх сарын ажлын гүйцэтгэлийг шалгуурын дагуу үнэлж, үнэлгээг нэгтгэн, нэгжийн нийт ажилчдын хурлын тэмдэглэлийн хамт сар бүрийн 5-ны өдөр багтаан Хүний нөөцийн албанд ирүүлж ажиллахыг дэд захирлууд, нийт албадын дарга, тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Алба, тасаг нэгжээс ирүүлсэн үнэлгээний хуудас болон хурлын тэмдэглэлийг хянаж, хариуцсан ажлын чиглэлээр санал, дүгнэлт өгч ажиллахыг тавдугаар хавсралтад нэр заасан албан тушаалтнуудад даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ерөнхий захирлын 2019 оны А/49 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ц.Билэгтсайхан Ц.БИЛЭГТСАЙХАН

УКЕ0053

106

ХӨСҮТөвийн Ерөнхий захирлын
2021 оны 10 сарын 06-ний өдрийн
А/209 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

# ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН МЭДЛИЙН ДАРГА НАРЫН АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

## Нэг. Тасгийн эрхлэгч, эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам

1. Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал, Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал, Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал, Чанарын албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг Ерөнхий захирал шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
2. Журмын 1.1-д заасан санал, дүгнэлтийг үндэслэн мөнгөн урамшуулал олгох тушаалын төслийг Хүний нөөцийн менежер боловсруулан, Ерөнхий захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
3. Хүний нөөцийн алба олгохоор батлагдсан мөнгөн урамшууллын жагсаалтыг тухайн захирал, дарга нарт танилцуулах ажлыг зохион байгуулна.
4. Ажлын үр дүнгийн урамшууллыг тухайн албан хаагчийн жинхэнэ ажилласан хугацаанд ногдох хувиар буюу ажилласан хоногийн тодорхойлолтод бичигдсэн хоногт ногдох хувиар тооцон олгоно.
5. Ажлын үр дүнгийн үнэлгээнд улиралд нэг удаа дараах үзүүлэлтийг үнэлж, 20 хүртэл оноогоор үнэлгээг нэмэгдүүлж болно. Үүнд:
   - Улсын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулга, семинарт илтгэл, өгүүлэл тавьж /хэвлүүлж/ оролцсон, ном товхимол хэвлүүлсэн,
   - Эмнэлгийн практикт хийж байгаагүй тусламж үйлчилгээний шинэ төрөл, технологи, инновацыг нэмэгдүүлж, амжилттай нэвтрүүлсэн /тохиолдлын тоог харгалзах/
   - Олон улсын болон улсын хэмжээний урлаг, спортын болон бусад төрлийн уралдаан тэмцээнд оролцож, шагналт байранд орж, амжилт гаргасан.
6. Дараах тохиолдолд ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохгүй. Үүнд:
   - Шинэ ажилтнуудад буюу ажилд шинээр ороод, 3 сар хүрэхгүй хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчдад (хүүхдээ асрах чөлөөнөөс эргэн орсон бол олгоно);
   - Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70-аас доош хувьтай байгаа тохиолдолд тухайн сард;
   - Ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд тушаал батлагдсан сараас эхлэн, сахилгын шийтгэлгүйд тооцох хүртэл хугацаанд буюу 1 жилийн хугацаанд;
   - Албан хаагчийн гаргасан алдаа, дутагдлыг Удирдлагын зөвлөл, Ёс зүйн салбар хороо, Өмч хамгаалах байнгын зөвлөл, нэгжийн хурлаар хэлэлцэн, тухайн сарын мөнгөн урамшууллыг олгохгүй байх дүгнэлт, шийдвэр гаргасан бол;

**Хоёр. Ерөнхий захирлын мэдлийн дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо, урамшууллын хувь хэмжээ**

Урамшуулал олгох сар:..................................... Огноо: ..........................

| Үр дүнгийн үндсэн шалгуур | Үндсэн шалгуурыг тодорхойлох үзүүлэлтүүд | Өгвөл зохих оноо | Дүгнэх албан тушаалтан | Нэрс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ..... | ..... |
| Нэг. Нийтлэг шалгуур үзүүлэлт | | | | | |
| 1. Тасгийн үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын байдал | 1.1. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тасаг, хамт олныг удирдан зохион байгуулсан байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Ерөнхий захирал | | |
| | 1.2. Үүрэг даалгаврын биелэлт – Мягмар гарагийн хуралдааны болон бусад шуурхай үүргийн биелэлт **10 оноо** | | | | |
| | 1.3. Ажлын хэсэг, хороо, зөвлөлд томилогдсон үүрэг оролцоо **10 оноо** | | | | |
| | 1.4. Албан хэрэг хөтлөлт, мэдээ тайлан хугацаандаа гаргасан байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-40** | | | |
| 2. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт | 2.1. Стандарт, удирдамж, тушаал, журмын хэрэгжилтийн хувь, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, оролцоо **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Ерөнхий захирал | | |
| | 2.2. Цахим эмнэлгийн хэрэгжилт, Real time, Up to date программыг хэрэгжүүлж, нутагшуулсан байдал **10 оноо** | | | | |
| | 2.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **10 оноо** | | | | |
| | 2.4. Халдвараас сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-40** | | | |
| 3. Ажлын хариуцлага, ёс зүйн байдал | 3.1. Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал **5 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 1-2 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 3-4 оноо<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 4.5-5 оноо | • Ерөнхий захирал | | |
| | 3.2. Сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн байдал **5 оноо** | | | | |
| | 3.3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал **5 оноо** | | | | |
| | 3.4. Байгууллагаас зохиосон сургалт, олон нийтийн ажлын идэвх, оролцоо, зохион байгуулалт **5 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-20** | | | |
| **Бүгд оноо** | | **0-100** | | | |
| **Урамшууллын хувь:**<br>- 90-100 оноонд – 11-20 хувь,<br>- 71-89 оноонд – 1-10 хувь | | | | | |
| Танилцсан /гарын үсэг/ | | | | | |

ДҮГНЭСЭН:
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ...................................

ХӨСҮТөвийн Ерөнхий захирлын
2021 оны 10 сарын 06-ний өдрийн
А/209 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

# ТАСГИЙН ЭРХЛЭГЧ НАР БОЛОН ЭМЧ НАРЫН АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

**Нэг. Тасгийн эрхлэгч, эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам**

1. Тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тасгийн эрхлэгч нарын хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, хурлын тэмдэглэл, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
2. Эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тасгийн эрхлэгч шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тасгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, хурлын тэмдэглэл, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
3. Журмын 1.1, 1.2-д заасан хурлаас гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн мөнгөн урамшуулал олгох тушаалын төслийг Хүний нөөцийн менежер боловсруулан, Ерөнхий захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
4. Тасгийн эрхлэгч, эмч нарт олгохоор батлагдсан мөнгөн урамшууллын жагсаалтыг тухайн тасгийн эрхлэгч нарт хүргүүлэх ба эмч нарт
5. танилцуулах ажлыг зохион байгуулна.
6. Ажлын үр дүнгийн урамшууллыг тухайн албан хаагчийн жинхэнэ ажилласан хугацаанд ногдох хувиар буюу ажилласан хоногийн тодорхойлолтод бичигдсэн хоногт ногдох хувиар тооцон олгоно.
7. Ажлын үр дүнгийн үнэлгээнд улиралд нэг удаа дараах үзүүлэлтийг үнэлж, 20 хүртэл оноогоор үнэлгээг нэмэгдүүлж болно. Үүнд:
   - Улсын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулга, семинарт илтгэл, өгүүлэл тавьж /хэвлүүлж/ оролцсон, ном товхимол хэвлүүлсэн,
   - Эмнэлгийн практикт хийж байгаагүй тусламж үйлчилгээний шинэ төрөл, технологи, инновацыг нэмэгдүүлж, амжилттай нэвтрүүлсэн /тохиолдлын тоог харгалзах/
   - Олон улсын болон улсын хэмжээний урлаг, спортын болон бусад төрлийн уралдаан тэмцээнд оролцож, шагналт байранд орж, амжилт гаргасан.
8. Дараах тохиолдолд ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохгүй. Үүнд:
   - Шинэ ажилтнуудад буюу ажилд шинээр ороод, 3 сар хүрэхгүй хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчдад (хүүхдээ асрах чөлөөнөөс эргэн орсон бол олгоно);
   - Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70-аас доош хувьтай байгаа тохиолдолд тухайн сард;
   - Эмнэлгийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд тушаал батлагдсан сараас эхлэн, сахилгын шийтгэлгүйд тооцох хүртэл хугацаанд буюу 1 жилийн хугацаанд;

- Албан хаагчийн гаргасан алдаа, дутагдлыг Захирлын зөвлөл, Ёс зүйн салбар хороо, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл, нэгжийн хурлаар хэлэлцэн, тухайн сарын мөнгөн урамшууллыг олгохгүй байх дүгнэлт, шийдвэр гаргасан бол;
- Гэрээт ажилчид, зөвлөх эмч, хуулийн зөвлөх, дотоод аудитор;

**Хоёр. Тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо, урамшууллын хувь хэмжээ**

Урамшуулал олгох сар:......................................  Огноо: ........................

| Үр дүнгийн үндсэн шалгуур | Үндсэн шалгуурыг тодорхойлох үзүүлэлтүүд | Өгвөл зохих оноо | Дүгнэх албан тушаалтан | Нэрс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ..... | ..... |
| Нэг. Нийтлэг шалгуур үзүүлэлт | | | | | |
| 1. Тасгийн үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын байдал | 1.1. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тасаг, хамт олныг удирдан зохион байгуулсан байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал | | |
| | 1.2. Үүрэг даалгаврын биелэлт – Мягмар гарагийн хуралдааны болон бусад шуурхай үүргийн биелэлт **10 оноо** | | | | |
| | 1.3. Үйл ажиллагааны эдийн засгийн үр дүн - Гүйцэтгэлээр санхүүжих журмын хэрэгжилт **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-30** | | | |
| 2. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт | 2.1. Стандарт, удирдамж, тушаал, журмын хэрэгжилтийн хувь, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, оролцоо **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь | • Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал | | |
| | 2.2. Цахим эмнэлэг төслийн хэрэгжилт, Real time, Up to date программыг хэрэгжүүлж, нутагшуулсан байдал | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **10 оноо** | бол Хангалттай буюу 9.5-10 оноо | | | |
| | 2.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар **10 оноо** | | | | |
| | 2.4. ХАБЭАхуйг Тасгийн хэмжээнд мөрдүүлэх, үйл ажиллагааны зохион байгуулалт **10 оноо** | | | | |
| | 2.5. Халдвараас сэргийлэх, Халдварын тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-50** | | | |
| 3. Ажлын хариуцлага, ёс зүйн байдал | 3.1. Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал **5 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 1-2 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 3-4 оноо<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 4.5-5 оноо | • Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал | | |
| | 3.2. Сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн байдал **5 оноо** | | | | |
| | 3.3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал **5 оноо** | | | | |
| | 3.4. Байгууллагаас зохиосон сургалт, олон нийтийн ажлын идэвх, оролцоо **5 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-20** | | | |
| **Бүгд оноо** | | **0-100** | | | |
| **Урамшууллын хувь:**<br>- 90-100 оноонд – 11-20 хувь,<br>- 71-89 оноонд – 1-10 хувь | | | | | |
| Танилцсан /гарын үсэг/ | | | | | |

ДҮГНЭСЭН:
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ ..................................

**Гурав. Эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо, урамшууллын хувь хэмжээ**

Урамшуулал олгох сар:...................................... Огноо: ......................

| Үр дүнгийн үндсэн шалгуур | Үндсэн шалгуурыг тодорхойлох үзүүлэлтүүд | Өгвөл зохих оноо | Дүгнэх албан тушаалтан | Нэрс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ..... | ..... |
| 1. Тасгийн үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын байдал | 1.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, багаар ажилласан байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Тасгийн эрхлэгч | | |
| | 1.2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын, шуурхай үүргийн биелэлт **10 оноо** | | | | |
| | 1.3. Үйл ажиллагааны эдийн засгийн үр дүн - Гүйцэтгэлээр санхүүжих журмын хэрэгжилт **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-30** | | | |
| 2. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт | 2.1. Стандарт, удирдамж, тушаал, журмын хэрэгжилтийн хувь, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, оролцоо **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Тасгийн эрхлэгч | | |
| | 2.2. Цахим эмнэлэг төслийн хэрэгжилт, Real time, Up to date программыг эзэмшиж, хэрэгжүүлсэн байдал **10 оноо** | | | | |
| | 2.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар **10 оноо** | | | | |
| | 2.4. Халдварын хяналт, сэргийлэлтийн журмын хэрэгжилт **10 оноо** | | | | |
| | 2.5. ХАБЭАхуй, халдварын тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний талаарх мэдлэг, хэрэгжилтийн байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-50** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3. Ажлын хариуцлага, ёс зүйн байдал | 3.1. Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал **5 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 1-2 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 3-4 оноо<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 4.5-5 оноо | • Тасгийн эрхлэгч | | |
| | 3.2. Сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн байдал **5 оноо** | | | | |
| | 3.3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал **5 оноо** | | | | |
| | 3.4. Байгууллагаас зохиосон сургалт, олон нийтийн ажлын идэвх, оролцоо **5 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-20** | | | |
| **Бүгд оноо** | | **0-100** | | | |
| **Урамшууллын хувь:**<br>- 90-100 оноонд – 11-20 хувь,<br>- 71-89 оноонд – 1-10 хувь. | | | | | |
| Танилцсан /гарын үсэг/ | | | | | |

ХЯНАСАН:
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ ..................................

ДҮГНЭСЭН:
ТАСГИЙН ЭРХЛЭГЧ ..................................

ХӨСҮТөвийн Ерөнхий захирлын
2021 оны 10 сарын 06-ний өдрийн
А/209 тоот тушаалын гуравдугаар хавсралт

# АЛБАДЫН ДАРГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

## Нэг. Албадын дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам

1. Албадын дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал, Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал, Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал нар үнэлэн, албадын дарга нарын хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэл, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
2. Албадад ажиллаж буй бусад ажилтан, мэргэжилтний /цаашид мэргэжилтнүүд гэх/ ажлын үр дүн, гүйцэтгэлийг албадын дарга нар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, албаныхаа хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргаж, хурлын тэмдэглэл, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
3. Хүний нөөцийн албаны болон Чанарын албаны даргын үнэлгээнд ерөнхий захирлын саналыг авч тусгасан байна.
4. Албадын дарга нарын хурлаас болон албадаас ирүүлсэн санал, дүгнэлтийг үндэслэн мөнгөн урамшуулал олгох жагсаалт, тушаалын төслийг Хүний нөөцийн мэргэжилтэн боловсруулан, Ерөнхий захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
5. Албадын дарга, мэргэжилтнүүдэд олгохоор батлагдсан мөнгөн урамшууллын жагсаалтыг тухайн албаны дарга нарт хүргүүлэх ба тухайн албаны албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.
6. Ажлын үр дүнгийн урамшууллыг тухайн албан хаагчийн жинхэнэ ажилласан хугацаанд ногдох хувиар буюу ажилласан хоногийн тодорхойлолтод бичигдсэн хоногт ногдох хувиар тооцон олгоно.
7. Ажлын үр дүнгийн үнэлгээг дараах үзүүлэлтийн дагуу улиралд нэг удаа үнэлж, 20 хүртэл оноогоор үнэлгээг нэмэгдүүлж болно. Үүнд:
    - Улсын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулга, семинарт илтгэл, өгүүлэл тавьж /хэвлүүлж/ оролцсон, ном товхимол хэвлүүлсэн,
    - Эмнэлгийн практикт байгаагүй шинэ санаа, санаачилга, инновацыг нэмэгдүүлж, амжилттай нэвтрүүлсэн /тохиолдлын тоог харгалзах/
    - Олон улсын болон улсын хэмжээний урлаг, спортын болон бусад төрлийн уралдаан тэмцээнд оролцож, шагналт байранд орж, амжилт гаргасан.

9. Дараах тохиолдолд ажлын үр дүнгийн урамшууллыг олгохгүй. Үүнд:
    - Шинэ ажилтнуудад буюу ажилд шинээр ороод, 3 сар хүрэхгүй хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчдад (хүүхдээ асрах чөлөөнөөс эргэн орсон бол олгоно);
    - Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70-аас доош хувьтай байгаа тохиолдолд тухайн сард;
    - Төвийн ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд тушаал батлагдсан сараас эхлэн, сахилгын шийтгэлгүйд тооцох хүртэл хугацаанд буюу 1 жилийн хугацаанд;

- Албадын дарга, мэргэжилтний гаргасан алдаа, дутагдлыг Ерөнхий захирлын зөвлөл, Ёс зүйн салбар хороо, Өмч хамгаалах байнгын комисс, нэгжийн хурлаар хэлэлцэн, тухайн сарын мөнгөн урамшууллыг олгохгүй байх дүгнэлт, шийдвэр гаргасан бол;

**Хоёр. Албадын дарга нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо, урамшууллын хувь хэмжээ**

Урамшуулал олгох сар:......................................   Огноо: .......................

| Үр дүнгийн үндсэн шалгуур | Үндсэн шалгуурыг тодорхойлох үзүүлэлтүүд | Өгвөл зохих оноо | Дүгнэх, санал өгөх албан тушаалтан | Нэрс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ..... | ..... |
| 1. Албаны үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын байдал | 1.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тасаг, хамт олныг удирдан зохион байгуулсан байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал<br>• Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд<br>• Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал | | |
| | 1.2. Үүрэг даалгаврын биелэлт – Мягмар гарагийн хуралдаанаас өгсөн болон шуурхай үүргийн биелэлт **10 оноо** | | | | |
| | 1.3. Хариуцсан албаны эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, арвилан хэмнэлт **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-30** | | | |
| 2. Албаны үйл ажиллагаан ы чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт | 2.1. Стандарт, удирдамж, тушаал, шийдвэр, журмын хэрэгжилтийн байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал<br>• Чанарын албаны дарга,<br>• Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал | | |
| | 2.2. Цахим эмнэлэг төслийн хэрэгжилт – албаны үйл ажиллагаанд ашиглаж буй программын хэрэглээний байдал **10 оноо** | | | | |
| | 2.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар **10 оноо** | | | | |
| | 2.4. Бусад нэгжүүдэд үндсэн чиг үүргийн хүрээнд өгсөн арга зүй | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөвлөмж, түүний үр дүнтэй байдал **10 оноо** | | | | |
| | 2.5. Халдварын тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-50** | | | |
| 3. Ажлын хариуцлага, ёс зүйн байдал | 3.1. Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал **5 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 1-2 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 3-4 оноо<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 4.5-5 оноо | • Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал<br>• Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд<br>• Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал | | |
| | 3.2. Сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн байдал **5 оноо** | | | | |
| | 3.3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал **5 оноо** | | | | |
| | 3.4. Байгууллагаас зохиосон сургалт, олон нийтийн ажлын идэвх, оролцоо **5 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-20** | | | |
| **Бүгд оноо** | | **0-100** | | | |
| **Урамшууллын хувь:**<br>- 90-100 оноонд – 11-20 хувь,<br>- 71-89 оноонд – 1-10 хувь | | | | | |
| Танилцсан /гарын үсэг/ | | | | | |

ДҮГНЭСЭН:
ДЭД ЗАХИРАЛ ....................................

**Гурав. Албадын мэргэжилтнүүдийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оноо, урамшууллын хувь хэмжээ**

Урамшуулал олгох сар:.....................................  Огноо: .......................

| Үр дүнгийн үндсэн шалгуур | Үндсэн шалгуурыг тодорхойлох үзүүлэлтүүд | Өгвөл зохих оноо | Дүгнэх, санал өгөх албан тушаалтан | Нэрс | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ..... | ..... |
| 1. Албаны үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын | 1.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тасаг, багаар ажилласан байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол | • Албаны дарга | | |
| | 1.2. Удирдлагаас өгсөн | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| байдал | үүрэг даалгаврын, шуурхай үүргийн биелэлт **10 оноо** | Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | | | |
| | 1.3. Анхан шатны баримт хөтлөлт, тайлан гаргасан байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-30** | | | |
| 2. Албаны үйл ажиллагааны чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт | 2.1. Стандарт, удирдамж, тушаал, шийдвэр, журмын хэрэгжилтийн байдал **10 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 8 оноо<br>• 80-89 хувьтай бол сайн буюу 9<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 9.5-10 оноо | • Албаны дарга | | |
| | 2.2. Цахим эмнэлэг төслийн хэрэгжилт – албаны үйл ажиллагаанд ашиглаж буй программын хэрэглээний байдал **10 оноо** | | | | |
| | 2.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар **10 оноо** | | | | |
| | 2.4. Бусад нэгжүүдэд үндсэн чиг үүргийн хүрээнд өгсөн арга зүйн зөвлөмж, түүний үр дүнтэй байдал **10 оноо** | | | | |
| | 2.5. ХАБЭАхүй, Халдварын тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал **10 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-50** | | | |
| 3. Ажлын хариуцлага, ёс зүйн байдал | 3.1. Ажлын цаг ашиглалт, ирцийн байдал **5 оноо** | Үзүүлэлт тус бүр:<br>• 70-аас доош хувьтай бол Хангалтгүй буюу – 0,<br>• 71-80 хувьтай бол дунд буюу 1-2 оноо | • Албаны дарга | | |
| | 3.2. Сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн байдал **5 оноо** | | | | |
| | 3.3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | санаачилга гарган ажилласан байдал **5 оноо** | • 80-89 хувьтай бол сайн буюу 3-4 оноо<br>• 90-100 хувь бол Хангалттай буюу 4.5-5 оноо | | | |
| | 3.4. Байгууллагаас зохиосон сургалт, олон нийтийн ажлын идэвх, оролцоо **5 оноо** | | | | |
| **Нийт** | | **0-20** | | | |
| **Бүгд оноо** | | **0-100** | | | |
| **Урамшууллын хувь:**<br>- 90-100 оноонд – 11-20 хувь,<br>- 71-89 оноонд – 1-10 хувь | | | | | |
| Танилцсан /гарын үсэг/ | | | | | |

ХЯНАСАН:
ДЭД ЗАХИРАЛ ....................................

ДҮГНЭСЭН:
АЛБАНЫ ДАРГА: ....................................

ХӨСҮТөвийн Ерөнхий захирлын
2021 оны 10... сарын 06-ний өдрийн
A/209 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

АХЛАХ СУВИЛАГЧ, СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ
АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

**Нэг. Ахлах сувилагч, сувилагч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам**

1. Ахлах сувилагч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тасгийн эрхлэгч үнэлэн, тасгийн хурлаар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, үнэлгээний хяналтын хуудасны хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
2. Сувилагч, тусгай мэргэжилтний ажлын үр дүн, гүйцэтгэлийг ахлах сувилагч, тасгийн эрхлэгч нар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тасаг, албаны хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргаж, хурлын тэмдэглэлийн хамт Хүний нөөцийн албанд ирүүлнэ.
3. Тасгуудаас ирүүлсэн санал, дүгнэлтийг нэгтгэн, үнэлгээний хяналт хийх эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан, санал авч, мөнгөн урамшуулал олгох тушаалын төслийг боловсруулан, Ерөнхий захиралд танилцуулж шийдвэрлүүлэх үүргийг тухайн асуудлыг хариуцсан Хүний нөөцийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.
4. Ахлах сувилагч, сувилагч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхдээ Сувилахуйн албаны дарга, арга зүйч нарын саналыг авах ба тухайн саналыг тусгах эсэхийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.
5. Ахлах сувилагч, сувилагч нарт олгохоор батлагдсан мөнгөн урамшууллын жагсаалтыг тухайн тасгийн ахлах сувилагч нарт хүргүүлэх ба ахлах сувилагч нар сувилагч нартаа танилцуулах ажлыг зохион байгуулна.
6. Ажлын үр дүнгийн урамшууллыг тухайн албан хаагчийн жинхэнэ ажилласан хугацаанд ногдох хувиар буюу ажилласан хоногийн тодорхойлолтод бичигдсэн хоногт ногдох хувиар тооцон олгоно.
7. Ажлын үр дүнгийн үнэлгээнд улиралд нэг удаа дараах үзүүлэлтийг үнэлж, 20 хүртэл оноогоор үнэлгээг нэмэгдүүлж болно. Үүнд:
   - Улсын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулга, семинарт илтгэл, өгүүлэл тавьж /хэвлүүлж/ оролцсон, ном товхимол хэвлүүлсэн,
   - Эмнэлгийн практикт байгаагүй шинэ санаа, санаачилга, инновацыг нэмэгдүүлж, амжилттай нэвтрүүлсэн /тохиолдлын тоог харгалзах/
   - Олон улсын болон улсын хэмжээний урлаг, спортын болон бусад төрлийн уралдаан тэмцээнд оролцож, шагналт байранд орж, амжилт гаргасан.
8. Дараах тохиолдолд ажлын үр дүнгийн урамшууллыг олгохгүй. Үүнд:
   - Шинэ ажилтнуудад буюу ажилд шинээр ороод, 3 сар хүрэхгүй хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчдад (хүүхдээ асрах чөлөөнөөс эргэн орсон бол олгоно);
   - Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70-аас доош хувьтай байгаа тохиолдолд тухайн сард;

- Төвийн ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд тухайн сараас эхлэн, сахилгын шийтгэлгүйд тооцох хүртэл хугацаанд буюу 1 жилийн хугацаанд;
- Ахлах сувилагч, сувилагчийн гаргасан алдаа, дутагдлыг Ерөнхий захирлын зөвлөл, Ёс зүйн салбар хороо, Сувилахуйн алба, Халдвар хамгааллын салбар хороо, Өмч хамгаалах байнгын комисс, нэгжийн хурлаар хэлэлцэн, тухайн сарын мөнгөн урамшууллыг олгохгүй байх дүгнэлт, шийдвэр гаргасан бол;

